



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот


Оюутны байрны төлбөр тогтоох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4, Төсвийн тухай хуулийн 6.2.3, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах журмын 10.8, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.4, 4.11.2, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. 2025-2026 оны хичээлийн жилд мөрдөх Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн оюутны дотуур байрны төлбөрийг нэгдүгээр хавсралтаар, оюутны байранд амьдардаг айл өрхийн төлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Оюутны дотуур байруудад засвар, тохижилтын ажил хийж, орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т үүрэг болгосугай.

3. Оюутны дотуур байруудын орчин нөхцөлийг сайжруулахтай холбогдон гарах зардлыг 2025 оны төсвийн тодотголын төсөлд тусган, хөрөнгө оруулалт, худалдан авалт, урсгал засварын ажлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т зөвшөөрсүгэй.



ДАРГА

Д.ГАНТУЛГА

367010006

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20..... оны дугаар сарын
 02 нийгдрийн дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ
 ОЮУТНЫ БАЙРНЫ ТӨЛБӨР

Оюутны байр	Төрөл	Багтаамж	Сарын төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)	
			Нэг оюутан	Оюутнаас авах барьцаа (жилд)
Оюутны I байр (ХШУС)	оюутан	4 хүний	91,900	30,000
	оюутан	1 хүний	294,300	30,000
	гадаад оюутан, мэргэжилтэн	2 хүний хагас люкс	273,100	30,000
	гадаад оюутан, мэргэжилтэн	2 хүний энгийн	252,400	30,000
Оюутны III байр (НХС)	оюутан	2 хүний	197,000	30,000
	оюутан	4 хүний	167,000	30,000
	гадаад оюутан	2 хүний	252,400	30,000
Оюутны IV байр (МХТС)	оюутан	4 хүний	91,900	30,000
Оюутны V байр (МИТС)	оюутан	4 хүний	91,900	30,000
ДаТС	оюутан	2 хүний	106,900	30,000
	оюутан	4 хүний	91,900	30,000

-- оОо --

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 20²⁵ оны ⁰⁵ дугаар сарын ⁰⁹ ний эдрийн ⁰³ дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



2025-2026 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД МӨРДӨХ
ОЮУТНЫ БАЙРАЙД АМЬДАРДАГ АЙЛ, ОРХИЙН ТОЛБОР

Оюутны байр	Өрөөний багтаамж м.кв	Нэг өрхийн сарын төлбөрийн хэмжээ (төгрөгөөр)				
		түрээс	цахилгаан	дулаан, халуун ус, цэвэр бохир ус	хог	нийт төлбөр
Оюутны III байр (НХС)	12 м.кв	187,000	25,900	36,900	2,200	251,900
	18 м.кв	228,300	28,600	40,700	2,400	300,000
Оюутны IV байр (МХТС)	18 м.кв	132,000	25,900	36,900	2,200	196,900
	36 м.кв	206,800	25,900	36,900	2,200	271,700
Оюутны V байр (МИТС)	9 м.кв	118,800	25,900	36,900	2,200	183,700
	12 м.кв	187,000	25,900	36,900	2,200	251,900
	18 м.кв	206,800	25,900	36,900	2,200	271,700
	24 м.кв	264,000	25,900	36,900	2,200	328,900

-- оОо --